

БАТЛАВ.
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА,
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАЖАВ

БАТЛАВ.
МОНГОЛЫН ШАТРЫН ХОЛБООНЫ
ТЭРГҮҮН ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ



Х.БАТЧУЛУУН

2026 ОНЫ МОНГОЛ УЛСЫН КОРПОРАЦИУДЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ “АЛТАН БЭРС” ЦОМЫН ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, дэмжин хөгжүүлэх хүрээнд Монгол Улсын ТОП-100 аж ауйн нэгж, байгууллагын дунд “Алтан бэрс” цомын төлөөх Корпорациудын шатрын аварга багийг тодруулах, 2026 онд зохион байгуулагдах Корпорациудын Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монгол Улсыг төлөөлөн оролцох багийг сонгон шалгаруулахад уг тэмцээний зорилго оршино.

Тэмцээнийг Олон Улсын Шатрын Холбоо (ФИДЕ) болон Монголын Шатрын Холбоо (МоШХ)-ны дүрмийн дагуу зохион байгуулна.

Хоёр. Зохион байгуулагч

- МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА, АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ
- МОНГОЛЫН ШАТРЫН ХОЛБОО

Гурав. Тэмцээний ангилал

Тэмцээн нь Монгол улсын шилдэг Топ-100 ААН, МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудын багуудад нээлттэй бөгөөд багийн төрлөөр зохион байгуулна.

Дөрөв. Тэмцээний бүртгэл

Тэмцээнд оролцох баг, тамирчид дараах mcfed.tournaments@gmail.com хаягаар бүртгүүлнэ.

Баг 5 гишүүнтэй байх ба тухайн тоглолтод 4 тоглогч тоглож, 1 сэлгээний тамирчин байна. Урилгаар 1 тамирчин оролцуулж болно. 4 тоглогч тухайн байгууллагын ажилтан байх ба сүүлийн 1 жил тухайн байгууллагад ажилласан байна. Мөн 1 тамирчин заавал эмэгтэй тоглогч байна. Багийн мэдүүлэгт тухайн байгууллагын ажилтныг тодорхойлсон албан бичиг, E-Mongolia аппликэйшны нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн лавлагааг хавсралтаар илгээж

баталгаажуулна. /Бичиг баримтын зөрчил үүссэн тохиолдолд тэмцээнд бүртгэх боломжгүй/

Багийн дундаж чансаа 2000-с хэтрэхгүй байна. /Монголын шатрын холбооны 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотоод чансаагаар бодох ба чансаагүй тамирчинг 1600-аар тооцно/

Тэмцээний хураамж 5,000,000 /Таван сая/ төгрөг байна. Хураамжийг Монголын Шатрын Холбооны Хаан банк дахь **IBAN дугаар MN62000500 5180754534** тоот дансанд тушаана.

Гүйлгээний утган дээр байгууллагын нэр болон холбоо барих ажилтны утасны дугаарыг бичнэ.

МҮХАҮТ-ын гишүүн байгууллагуудад хураамжийн 10%-ийн хөнгөлөлт үзүүлнэ.

Тэмцээний бүртгэлийн хугацаа: 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагт дуусгавар болно. Бүртгэлийн хугацаа дууссанаас хойш нэмж баг бүртгэхгүй.

Хураамж төлөгдөөгүй бол оноолтод оруулахгүй.

Тав. Тэмцээний журам

Тэмцээн 2026 оны 03 дугаар сарын 28-29-ний өдрүүдэд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын "Их танхим"-д явагдана.

Тэмцээнийг Монголын Шатрын Холбооны Шүүгчдийн зөвлөлөөс томилсон Улсын шүүгчийн эрхтэй шүүгчид шүүн явуулна.

Ширээний дараалал:

1-р ширээ Урилгаар оролцох тамирчин

2-р ширээ Эрэгтэй-1

3-р ширээ Эрэгтэй-2

4-р ширээ Эмэгтэй

Сэлгээний тамирчин /3-р ширээнд сэлгээгээр суух боломжтой/

Баг 5 гишүүнтэй байх ба тухайн тоглолтод 4 тоглогч тоглож, 1 сэлгээний тамирчин байна. Тойрог бүрийн өмнө багийн ахлагч, шүүгчид анхны жагсаалтын дарааллыг баримтлан тухайн тойрогт оролцох 4 тоглогчийн нэрийн жагсаалтыг өгнө.

Тэмцээн швейцарь системээр 9 өрөг тоглоно.

Тэмцээний цагийн хяналт талдаа 25 минут байх ба нүүдэл бүрт 10 секунд нэмэгдэлтэй байна.

Ерөнхий шүүгчийн шийдвэр эцсийнх байна.

Зургаа. Хайна хагалах чанарын үзүүлэлт

Оноо тэнцсэн тохиолдолд дараах чанарын үзүүлэлтийг харгалзана.

- Багийн хожил хожсон баг 2 оноо, тэнцсэн баг 1 оноо, хожигдолд 0 оноо
- Багийн нийт оноо
- Багийн хоорондын тоглолтын харьцааг харгалзана.
- 1-р ширээний авсан оноо

Долоо. Тэмцээний цагийн хуваарь

№	Арга хэмжээ	Өдөр	Цаг
7	Нээлтийн ажиллагаа	2026/03/28	09:30
1	1-р өрөг	2026/03/28	10:00
2	2-р өрөг	2026/03/28	11:30
3	Цайны цаг	2026/03/28	13:00-14:30
4	3-р өрөг	2026/03/28	14:30
5	4-р өрөг	2026/03/28	16:00
6	5-р өрөг	2026/03/28	17:30
8	6-р өрөг	2026/03/29	10:00
9	7-р өрөг	2026/03/29	11:30
10	Цайны цаг	2026/03/29	13:00-14:30
11	8-р өрөг	2026/03/29	14:30
12	9-р өрөг	2026/03/29	16:00
13	Хаалтын ажиллагаа	2026/03/29	18:00

Найм. Шагнал урамшуулал

Багийн аварга:

1-р байр "Алтан бэрс" цом, Алтан медаль, Өргөмжлөл, 30,000,000 төгрөг

2-р байр Мөнгөн медаль, Өргөмжлөл, 20,000,000 төгрөг

3-р байр Хүрэл медаль, Өргөмжлөл, 10,000,000 төгрөг

4-р байр Өргөмжлөл, 8,000,000 төгрөг

5-р байр Өргөмжлөл, 5,000,000 төгрөг

Ширээний аварга бүр:

1-р ширээний аварга Алтан медаль, Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

2-р ширээний аварга Алтан медаль, Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

3-р ширээний аварга Алтан медаль, Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

4-р ширээний аварга Алтан медаль, Өргөмжлөл, 2,000,000 төгрөг

Ес. Сонгон шалгаруулалт

Тэргүүн байранд шалгарсан баг **КОРПОРАЦИУДЫН ДЭЛХИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНД** Монгол Улсыг төлөөлөн оролцох эрхтэй болно.

Арав. Бусад

Хувцаслалтын код: Баг бүр корпораци байгууллагын лого, нэртэй хүрэм, цамц, футболк эсвэл поло цамц өмсөхийг зөвлөж байна.

Цахим хэрэгсэл: Гар утас, электрон төхөөрөмж, бугуйн цаг (бүх төрлийн бугуйн цаг), хувийн үзэг зэргийг тэмцээний зааланд оруулахыг хориглоно. Тоглогчид гар утсыг унтрааж, бусад цахим хэрэгсэл (ухаалаг цаг, утас, нөүтбүүк... гэх мэт)-ийн хамт хадгалуулна. Тоглогч энэ журмыг зөрчиж, цахим хэрэгсэлтэй байвал, цахим хэрэгсэл (бусад эх үүсвэр) ашигласан нь нотлогдвол тухайн өргийг хожигдсонд тооцно.

Хууран мэхлэлтийн эсрэг дүрэм: Хууран мэхлэлтийн эсрэг дүрмийг хангах зорилгоор илрүүлэгч төхөөрөмжөөр санамсаргүйгээр шалгана. Тоглогч тавьсан шаардлагыг биелүүлэн оролцоно.

Арван нэг. Холбоо барих

Утас: 88708899, 99994193, 88271717

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС